



МОНГОЛЫН ТӨМӨР ЗАМ

“МОНГОЛЫН ТӨМӨР ЗАМ” ТӨХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2025 оны 03 сарын 20 өдөр

Дугаар 05

Улаанбаатар хот

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулах тухай

Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.4, 59.10, 59.11, 60 дугаар зүйлийн 60.2, 62 дугаар зүйлийн 62.1, 76 дугаар зүйлийн 76.1.2, 76.1.3, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2025 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн А-1/558 дугаар удирдамж, “Монголын төмөр зам” ТӨХК-ийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.3.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. “Монголын төмөр зам” ТӨХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2025 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн 11.00 цагт Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хурлын танхимд зарлан хуралдуулсугай.

2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын хэлэлцэх асуудлыг хавсралтаар баталсугай.

3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг Хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчээр даргалуулсугай.

4. Хувьцаа эзэмшигчдэд хурлын зарыг хүргүүлэх, хуульд заасан бичиг баримтыг танилцуулах, хурлын бэлтгэл ажлыг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулж ажиллахыг Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч /О.Батчулуун/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Б.АРТУР

“Монголын төмөр зам” ТӨХК-ийн Төлөөлөн
Удирдах Зөвлөлийн 2025 оны 03 дугаар
сарын 20-ний өдрийн 05 тогтоолын
хавсралт



**“МОНГОЛЫН ТӨМӨР ЗАМ” ТӨХК-ИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛААР
ХЭЛЭЛЦҮҮЛЭХ АСУУДАЛ**

№	Хэлэлцэх асуудал	Хугацаа	Шийдвэрийн төсөл	Танилцуулах албан тушаалтан
1	“Монголын төмөр зам” ТӨХК-ийн 2024 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлөөс гаргасан дүгнэлтийг батлах тухай	20 минут	Тогтоол	О.Батчулуун Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч